

Биеийн тамир спортын газрын 2020 онд хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын талаархи зөвлөмж, түүний биелэлтийн тайлан

2020.06.29

2018, 2019 оны санхүүгийн баримтанд өгсөн аудитын зөвлөмж	Хийсэн ажлын биелэлт	Хугацаа
1. Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу санхүүгийн баримт дугаарлах , товъёо хийх, баталгааны хуудас хийх	2020 оноос эхлэн санхүүгийн баримтыг дугаарлан товъёо хийж, баталгааны хуудас хийж эхэлсэн. - Ажилтнуудын хувийн хэрэгт хөдөлмөрийн дэвтэр, НДД-ийг хуулбарлан хавсаргасан - Ажилчдын ажилласан жилийн тооцоог гарган баталгаажуулсан - Хувийн хэргийн хөтлөлт баяжуулалтын бүрэн цэгцэлж дуусгасан.	Сар бүр
2. Тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөөгүй , жолоочийн замын хуудасны тооцоог бодох	Corolla маркийн автомашинд Тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтөлсөн 2018, 2019 оны тухайн автомашины шинээр худалдан авсан эд анги сэлбэгийг хувийн хэрэгт бүртгэсэн болно.	Сар бүр
3. Ажлын цагийн тооцоог цаг бүртгэгч сайн хөтлөх	Ажлын цагийг тооцоог цаг тухай бүр үнэн зөв хөтлөх талаар бүртгэгчдэд арга хэмжээ авч ажилласан.	Өдөр бүр
4. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хийсэн ажлын тайлан	Өмч хамгаалах зөвлөлийн 2019 оны тайланг нөхөн гаргах тал дээр өмч хамгаалах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгож , тайланг гарган ажилласан. Тайланг 2019 онд гаргасан өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу бэлтгэн гаргасан болно.	Жилд 1 удаа

5. Цалингийн картыг тусгайлан үдэж гарын үсэг зуруулах	2019 оны ажилчдын цалингийн картыг байнга хадгалагдах баримт гэж үзэн тусгайлан үдэж баталгаажуулсан болно.	бүтэн жилээр
6 Материалын тайланг зардлын зүйл анги бүрээр гаргаж үлдэгдлийг тооцох, складны бүртгэл хөтлөх	2020 оны 01 сараас хэрэгжүүлж эхэлсэн.	Сар бүр
7 Орлогын тооцоог тогтмол хийх	2019 онд нийт 10 байгууллагатай, заал ашиглалтын гэрээ хийн гэрээний биелэлтийг тооцож орлого бүрдүүлсэн. Мөн биеийн тамир тэмцээн уралдаанаас олох орлого болон мандаг болон бусад орлогыг хариуцсан дасгалжуулагч багш нар, няравтай тооцоо хийн хяналт тавин өөрийн орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна.	Тухай бүр

Тайлан гаргасан



Б Пүрэвсүрэн

УВС АЙМГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 34.01/06

Улаангом

2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Улсын байцаагчийн дугаар 34-01

Нэг. Нийтлэг зүйл.

Аймгийн дотоод аудитын хорооны даргын 2020 оны 02-р сарын 13-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Увс аймгийн Биеийн тамир спортын газрын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлт дүгнэлт өгөх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хүртэл Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Чойжилсүрэн ажиллаа.

2018 онд 475,7 мянган төгрөгийн, 2019 онд 530,2 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авч жил бүр Төрийн аудитын газраар санхүүгийн гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж тайлангийн дүнгээ ажилчдын хурлаар оруулан хэлэлцэж ажилласан байна.

Байгууллагадаа 19,5 мянган төгрөгөөр фитнесийн тоног төхөөрөмж, ОНХС-аас 15,0 мянган төгрөгөөр боксын ринг, хандив /УИХ-ын гишүүн Б. Чойжилсүрэн/-аар УАЗ пургон машин 18,6 мянган төгрөг, хандиваар /УИХ-ын гишүүн Н.Цэрэнбат/ Таеквондогийн иж бүрэн дэвжээ 2,0 мянган төгрөг, УТХО-аар 80,0 мянган төгрөгний засвар, 4,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий усан бассейн, спорт фитнесийн барилга зэрэг хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

Увс аймгийн Биеийн тамир спортын газрын 1-р гарын үсгийг Дарга Б.Ганболд, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Пүрэвсүрэн, Г.Пагмасүрэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байсан.

2018 онд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар автомашины хувийн хэрэг хөтлөлт дутуу, тооцоо бодолт байхгүй, техникийн комиссын дүгнэлтгүй, ээлжийн амралтын мөнгийг буруу тооцсон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, нэмэлт санхүүжилтээр олгосон мөнгөний анхан шатны баримт бүрдэл дутуу, ур чадварын нэмэгдэл олгосон тушаал гаргаагүй зэрэг зөрчил

орлого, нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэр олж үйл ажиллагаагаа явуулж байна.

Өглөг авлагын тооцоо

Үзүүлэлт	2018 он	2019 он	Зөрүү	
			Өссөн	Буурсан
Өглөг	7,1	6,4		0,7
Авлага	391,9	0		391,9

Тус газар нь 2018, 2019 онд авлагыг тэгэлж, өглөгийг бууруулж ажилласан байна.

Гурав. Санхүү бүртгэлийн ажлын талаар:

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг стандартын дагуу хийж тайлан балансаа хуулийн хугацаанд гаргах, шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлж хэвшсэн зэрэг тодорхой ажлыг санаачлан зохион байгуулж ажиллажээ. Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн ажиллаж, тайлан балансаа хугацаанд нь гаргаж хэвшсэн байна.

Төсвийн хөрөнгийг зарцуулахад гарсан зөрчил дутагдлын талаар.

а/ Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу санхүүгийн баримтыг дугаарлаагүй, товёог хийгээгүй, баталгааны хуудас хийгээгүй.

б. Тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөөгүй, жолоочийн замын хуудасны тооцоог Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасны дагуу бодоогүй.

в. Ажлын цагийн тооцоог цаг бүртгэгч баланслуулаагүй.

г. Байгууллагын өмч хамгаалах зөвлөл, дотоод хяналтын нэгжийг байгуулсан боловч хийсэн ажлын тайлан байхгүй.

д. Цалингийн картыг тусгайлан үдэж гарын үсэг зуруулж хадгаламжийн нэгж үүсгээгүй.

е. Материалын тайланг зардлын зүйл анги бүрээр гаргаж үлдэгдлийг тооцоогүй, складын бүртгэл хөтөлж үлдэгдлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

ё. Тамирчны мандатын тооцоо зөрүүтэй, бэлэн мөнгө шууд зарцуулсан, байгууллагын харилцах дансанд орлогыг 24 цагийн тушаадаггүй.

ж. Заалны болон фитнесийн орлогын тооцоог тогтмол хийдэггүй.

Дөрөв. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад өгсөн санал, дүгнэлт:

а. Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу санхүүгийн баримтыг бүрдүүлэх

б. Тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтөлж, жолоочийн замын хуудасны тооцоог Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасны дагуу бодох

в. Ажлын цагийн тооцоог сайн хөтөлж байх

г. Байгууллагын өмч хамгаалах зөвлөл, дотоод хяналтын нэгжийг ажлын төлөвлөгөөтэй болгох, хийсэн ажлын бичмэл тайлан бичүүлж ажлын үр дүнг хэлэлцэж байх

д. Цалингийн картыг тусгайлан үдэж хадгаламжийн нэгж үүсгэж байх

е. Материалын тайланг зардлын зүйл анги бүрээр гаргаж, складын бүртгэл хөтөлж үлдэгдлийг нягтлан бодогч сар бүр гарын үсэг зурж баталгаажуулж байх

ё. Өөрийн орлогын тооцоонд тавих санхүүгийн хяналтыг сайжруулах

Төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд 20 оноо буюу 15.4 хувьтай шалгагдан "бага эрсдэлтэй" буюу санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт "Хангалттай" түвшинд хэрэгжиж байна.

Улсын байцаагчдын өгсөн үүрэг зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хангагдах хүртэл тайлангаа Санхүүгийн хяналт, аудитын албанд ирүүлэх хэрэгтэй.

Тав. Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт:

Зөвшөөрж байна.

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧ

Д.ЧОЙЖИЛСҮРЭН

ТАНИЛЦСАН:

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН

ДАРГА

Б.ГАНБОЛД

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ПҮРЭВСҮРЭН